

PwC Легал ХХН нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, ажилд авах, байгууллагын бүтцийн өөрчлөлт дагасан ажиллах хүчний өөрчлөлт, шилжилт, хил дамнасан хөдөлмөр эрхлэлт, нэгдэж нийлэх ажиллагаанаас үүсэх хөдөлмөрийн асуудлууд, хөдөлмөрийн маргаан, хөдөлмөрийн харилцаанд гарч ирж буй шинэ тутам асуудлууд болон олон улсын стандартын нийцлийн шалгалт зэрэг хөдөлмөрийн эрх зүйн асуудлаар өргөн хүрээний үйлчилгээг санал болгодог.

Санал болгож буй үйлчилгээ



Хөдөлмөрийн харилцааны баримт бичиг бэлтгэх

Бид таны хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ зэрэг хөдөлмөрийн харилцааны баримт бичиг боловсруулах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- **Хөдөлмөрийн харилцааны баримт бичиг.** Хөдөлмөрийн гэрээний бүхий л төрлүүд, тушаал шийдвэр болон байгууллагын дотоод журам, бодлого боловсруулах, хянах.
- **Удирдлагатай байгуулах гэрээ.** Гүйцэтгэх удирдлага болон удирдах түвшний ажилтантай байгуулах гэрээг боловсруулах, хянах.
- **Олон улсад хөдөлмөр эрхлэх.** PwC-н татвар болон гадаадын иргэн харьяатын үйлчилгээний мэргэжилтнүүдтэй хамтран, хил дамнаж буюу олон улсад ажиллах харилцааг зохицуулсан гэрээ, баримт бичиг боловсруулах.



Хөдөлмөрийн хууль тогтоомжийн нийцэл

Бид хөдөлмөрийн хууль тогтоомжийн нийцлийн хангахад туслалцаа үзүүлэн дараах үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- **Хөдөлмөрийн хууль тогтоомжийн нийцлийн шалгалт.** Байгууллагууд, ялангуяа удирдлагуудад хууль тогтоомжийн нийцлийг хэр түвшинд хангаж байгааг ойлгуулах зорилгоор тус шалгалтыг хийдэг. Мөн, шаардлагатай бол хэрхэн хуулийн нийцлийг хангах талаарх зөвлөгөө өгдөг.
- **Хөдөлмөрийн хуулийн зөвлөгөө.** Танд хөдөлмөрийн хууль тогтоомжийн өөрчлөлтүүдийг ойлгож, цаг тухайд нь дагаж мөрдөхөд туслалцаа, эрсдэлийг удирдаж, нэр хүндийг тань хамгаалахад чиглэсэн хөдөлмөрийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
- **Сургалт.** Хөдөлмөрийн тухай хууль, олон талт байдал ба оролцоо зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцааны өргөн хүрээний сэдвүүдээр таны хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтуудыг санал болгодог.



Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх

Манай хөдөлмөрийн эрх зүйн мэргэшсэн хуульч нар нь хөдөлмөрийн харилцааны туршид үйлчлүүлэгчдэд шаардлагатай туслалцааг үзүүлдэг бөгөөд ялангуяа хөдөлмөр эрхлэлтийг дуусгавар болгох үйл ажиллагаатай холбоотой зөвлөх үйлчилгээг илүүтэй үзүүлдэг. Бид эрсдэлийг бууруулах, маргаантай нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх хэлбэрээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль зүйн зөвлөгөөг өгдөг.

Хэрэв хөдөлмөрийн маргаан гарсан тохиолдолд бид шүүх болон төрийн байгууллагуудын өмнө таныг төлөөлөх, үйлдвэрчний эвлэл болон ажилтнуудтай хийх хэлэлцээний бүх үе шатанд туслалцаа үзүүлэх зэрэг хөдөлмөрийн маргааны аль ч шатанд өргөн хүрээний хууль зүйн туслалцааг үзүүлнэ.



Хүний эрхийн магадлан шинжилгээ / Хөдөлмөрлөх эрхийн үнэлгээ

Бид хүний эрхийн чиглэлээрх олон улсын туршлагадаа тулгуурлан зөвхөн хуулийн нийцлийн шаардлагаас давуулан иж бүрэн хүний эрхийн магадлан шинжилгээний үйлчилгээг үзүүлдэг.

Энэхүү магадлан шинжилгээг гүйцэтгэхдээ ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, түүнд учирч буй бодит болон болзошгүй эрсдэлүүдийг илрүүлэх зорилгоор эрсдэлийн болон хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийдэг. Үүний дараа бид тантай хамтран олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн болон сайн туршлагад тулгуурлан хүний эрхийн эрсдэлийг арилгах, бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зөвлөгөөг өгч ажилладаг.

Бидний давуу тал



Салбарын мэдлэг, туршлага

Бид бизнесийн салбарын онцлог, шаардлагыг сайн мэддэг тул үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлдэг.



Хөдөлмөрийн эрх зүйн мэргэшсэн байдал

Бид хөдөлмөрийн харилцааны аливаа асуудлаас урьдчилсан сэргийлэх, хуулийн нийцлийг хангах мэргэшсэн зөвлөгөөг өгөх болно.



Зөвхөн хуулийн үйлчилгээгээр хязгаарлагдахгүй

Бид шаардлагатай тохиолдолд татвар, санхүүгийн үйлчилгээний багтай хамтарсан үйлчилгээг үзүүлдэг.



Нягт хамтын ажиллагаа

Бид танай санхүүгийн алба, нягтлан зэрэг аливаа ажилтнуудтай хялбар ойлголцож, нягт хамтран ажиллах болно.



Цаг тухай бүр шуурхай үйлчилгээ

Таны хэрэгцээнд нийцүүлэн цаг тухай бүр шуурхай хариу өгөх болно.



370,000+
мэргэжилтнүүд



Дэвшилтэт технологи

Хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр үйлчилгээ үзүүлэхдээ бид дэвшилтэт технологи, хэрэгслийг ашигладаг.



149
улс

86%

Fortune Global 500 жагсаалт дах манай үйлчлүүлэгчид



3,000+
хуульчид



Legal500, Chambers & Partners, болон IFLR1000 зэрэг бие даасан зэрэглэл тогтоодог байгууллагууд манай хуулийн фирмийг зах зээл дэх тэргүүлэгч хуулийн фирмийн нэгээр үнэлсэн байдаг.

Таны асуудлууд нарийн төвөгтэй байж болох ч бид тохирсон шийдлийг санал болгох болно. PwC таныг чухал үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэхийн төлөө ажилладаг. Энэ цаг үе бол ажлын арга барилаа эргэн харж, шинэ боломжуудыг нээх хамгийн тохиромжтой цаг юм. Илүү уян хатан, хууль тогтоомжид нийцсэн үйлчилгээг сонирхож байвал бидэнтэй холбогдоорой.

Бидэнтэй холбогдоорой.



Серги Кобахидзе
Партнер
PwC Евроази
sergi.kobakhidze@pwc.com



Р.Мөнхжаргал
Хуулийн ахлах менежер
PwC Монгол
munkhargal.ragchaakhuu@pwc.com



О.Мөнхнасан
Ахлах хуульч
PwC Монгол
munkhnasan.otgontogtool@pwc.com

Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

603 тоот, Централ Тауэр,
СБД-8, Улаанбаатар, Монгол
Улс -14200

Утас: + 976 70009089

www.pwc.com/mn



© 2026 PwC Монгол. Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ. Дэлгэрэнгүйг www.pwc.com/structure холбоосоор үзнэ үү.